МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 21 өдөр Дугаар А/123 Мөрөн сум

Тусгай зөвшөөрлийг шинээр олгох,
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.5, 16 дугаар зүйлийн 16.2.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1, 19.3.5, 19.17, 19.18, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 400 дүгээр тушаалыг үндэслэн тус тус ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дуудлага худалдаагаар авсан болон шинээр тусгай зөвшөөрөл авах хүсэлт ирүүлсэн эмийн сангийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн байгууллагуудын жагсаалтыг 1 дүгээр, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах аж ахуй нэгж байгууллагын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр), Эрүүл мэндийн газрын (М.Үүрийнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Эрүүл мэндийн багц хууль, эрүүл мэндийн байгууллагууд, эмийн сангуудад холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамжуудыг мөрдөж ажиллахыг эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд даалгасугай.

4.Энэхүү захирамжийг эс зөвшөөрвөл 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5. Суманд үйл ажиллагаа явуулж байгаа Хөвсгөлийн эмийн эргэлтийн сан ХК-ны харъяа "Эмийн эргэлтийн сангууд" дуудлага худалдаагаар худалдагдсан тул аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/547 дугаар захирамж, аймгийн Засаг даргын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/473 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 19 дүгээр мөрний Чандмань-Өндөр сумын "Сайханшид"эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг тус тус хүчингүй болгосугай.

6.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2022

Аймгийн Засаг даргын 2022 оны 04
дүгээр сарын 21..-ны өдрийн А/123
дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ШИНЭЭР ОЛГОХ БАЙГУУЛЛАГУУДЫН НЭРС

№	Байгууллагын нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Эрхлэх үйл ажиллагааны чиглэл	Ажлын байрны хаяг	Тусгай зөвшөөрлийн хугацаа
1	"Их Уул гэгээ" ХХК-ний "Их Уул" эмийн сан	Д.Оюун-Эрдэнэ	2-р зэрэглэлийн эмийн сан	Их-Уул сум	2022-04-21 2025-04-21
2	"Дэлгэрэх рашаан" ХХК-ний "Бадмаанямбуу" эмийн сан	Д.Сайнбуян	2-р зэрэглэлийн эмийн сан	Галт сум	2022-04-21 2025-04-21
3	"Хатан дэвүүр" ХХК-ний "Эрхэм жаргалан" эмийн сан	Н.Эрдэнэ жаргал	2-р зэрэглэлийн эмийн сан	Жаргалант сум	2022-04-21 2025-04-21
4	"Нуурын булаг" ХХК-ний "Арвижих" эмийн сан	О.Отгонням	2-р зэрэглэлийн эмийн сан	Цагаан Нуур сум	2022-04-21 2025-04-21
5	Үрэл арвижих ХХК-ний "Үрэл арвижих" эмийн сан	Ж.Эрдэнэцэцэг	2-р зэрэглэлийн эмийн сан	Түнэл сум	2022-04-21 2025-04-21
6	"Наран нэмэн" ХХК-ний "Лидэр фарм" эмийн сан	А.Нарантуяа	2-р зэрэглэлийн эмийн сан	Хатгал тосгон	2022-04-21 2025-04-21
7	"Жанст тун" ХХК-ний "Жанст тун" эмийн сан	Г.Ичинхорлоо	2-р зэрэглэлийн эмийн сан	Тосонцэнгэл сум	2022-04-21 2025-04-21
8	Монос Хөвсгөл ХХК -ний "Рашаант-Монос" эмийн сан	М.Золзаяа	2-р зэрэглэлийн эмийн сан	Рашаант сум	2022-04-21 2025-04-21
9	"Монос Хөвсгөл" ХХК – ний "Цагаан-Үүр-Монос" эмийн сан	Б.Болормаа	2-р зэрэглэлийн эмийн сан	Цагаан Үүр сум	2022-04-21 2025-04-21
10	"Монос Хөвсгөл" ХХК – ний "Цэцэрлэг-Монос" эмийн сан	Б.Ичинхорлоо	2-р зэрэглэлийн эмийн сан	Цэцэрлэг сум	2022-04-21 2025-04-21
11	"Алтан талын цацал " ХХК-ний "Цацат" эмийн сан	Б.Буянхишиг	2-р зэрэглэлийн эмийн сан	Рэнчинлхүмбэ сум	2022-04-21 2025-04-21
12	"Хотор Арвис" ХХК-ний "Цагаан Уул" эмийн сан	Т.Ганчулуун	2-р зэрэглэлийн эмийн сан	Цагаан-Уул сум	2022-04-21 2025-04-21
13	"Бүрэнтөгс рашаан" ХХК-ний "Бүрэнтөгс рашаан" эмийн сан	Б.Эрдэнэчимэг	2-р зэрэглэлийн эмийн сан	Бүрэнтогтох сум	2022-04-21 2025-04-21

14	"Энх шишгэд" ХХК-ний "Энх шишгэд" эмийн сан	Б.Бумдарь	2-р зэрэглэлийн эмийн сан	Улаан-Уул сум	2022-04-21 2025-04-21
15	"Эх жугнай" ХХК-ний "Анар" эмийн сан	Б.Долгоржав	2-р зэрэглэлийн эмийн сан	Цэцэрлэг сум Могойн голын уурхай	2022-04-21 2025-04-21
16	"Хүслэн өгөөж" ХХК-ний "Онош мед" лаборатори	О.Түмэнхүү	Лаборатори	Мөрөн сум 8-р баг 14-4 тоот "Мөнхтулгуур" эмнэлгийн байр	2022-04-21 2025-04-21

_____oOo_____

Аймгийн Засаг даргын 2022 оны 04
дүгээр сарын 21..-ны өдрийн
А/123 дүгээр захирамжийн 2 дугаар
хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ХУГАЦААГ СУНГАХ БАЙГУУЛЛАГЫН НЭР

№	Байгууллагын нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Эрхлэх үйл ажиллагааны чиглэл	Ажлын байрны хаяг	Тусгай зөвшөөрлийн хугацаа
1	"Гуамөрөн" ХХК	Л.Гэрэлхүү	Дотор, хүүхдийн тусламж үйлчилгээ	Тариалан сум "Мандал" баг	2022-05-02 2027-05-02

_____oOo_____